



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/600

Мөрөн сум

Отрын штаб байгуулж, штабын ажиллах
түр журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, заалт, Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд 2023-2024 оны өвөл, хавар өөрийн аймгийн сум хооронд болон зэргэлдээ аймгийн нутагт отроор өвөлжиж байгаа малчдад эрүүл мэнд, нийгэм, төрийн үйлчилгээг зохицуулах "Аймгийн отрын штаб"-ыг байгуулж, бүрэлдэхүүнийг нэгдүгээр, аймгийн отрын штабын ажиллах түр журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт отор нүүдлийн зориулалтаар тээвэрлэх, тууварлах малын шилжилт хөдөлгөөн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт тавих журмын хэрэгжилтийг ханган, мал сүргийг эрүүл мэндийн үзлэгт хамруулж, мэргэжил арга зүй удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т, отор нүүдлийн судалгааг нарийвчлан гаргаж, отрын бүсийн замын маршрут зураглал гаргаж нөхцөл байдлын үнэлгээ хийх, малчдад зөвлөмж заавар хүргүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т, өвөлжилт, отор нүүдэлтэй холбоотой асуудлыг холбогдох эрх зүйн актын хүрээнд орон нутгийн түвшинд хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдын талаар холбогдох судалгаа, мэдээллийг нарийвчлан гаргаж, малчдын сургуулийн насны хүүхдийг тухайн очсон сумдын сургуульд хамруулах, хүн, мал эмнэлэг, соёл, холбоо мэдээлэл, төрийн үйлчилгээгээр үйлчлэх асуудлыг сумдын удирдлагуудтай хамтран зохицуулж, малчдыг тав тухтай өвөлжүүлж, хаваржуулах арга хэмжээ авч ажиллахыг "Аймгийн отрын штабын дарга" (аймгийн Засаг даргын Орлогч дарга)-д үүрэг болгосугай.

6712011388

2.

4. Аймаг, сумдын отрын штабуудын байрлах байр, унаа, түлш шатахуун, хоол, холбоо мэдээлэл болон бусад үйл ажиллагаатай холбогдон гаргах зардлыг холбогдох зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар.)-т зөвшөөрсүгэй.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Осөх)-д даалгажугай.

ДАРГА



О.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр
сарын 21 өдрийн 4/60 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт



ОТРЫН ШТАБЫН АЖЛЫН ХЭСЭГ

Штабын дарга: Аймгийн Засаг даргын орлогч


Штабын орлогч дарга: Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүдэд: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

- Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
- Онцгой байдлын газрын дарга
- Хөдөө аж ахуйн газар
- Эрүүл мэндийн газрын дарга
- Цагдаагийн газрын дарга
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга
- Ус цаг уур, орчны шинжилгээний албаны дарга
- Мал эмнэлгийн газрын дарга
- Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Нарийн бичгийн дарга: Хүнс, Хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 21 өдрийн 7820 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ОТРЫН ШТАБЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

Зорилго: Аймаг, сумын отрын штабаас өөрийн аймгийн сум хооронд болон хөрш зэргэлдээ аймгийн нутагт отроор өвөлжиж байгаа малчдад эрүүл мэнд, нийгэм, соёл, төрийн үйлчилгээ үзүүлэх, тэдний мал сүргийг хохирол багатай өвөлжүүлж, хаваржихтай холбогдсон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх явцад үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1 Аймаг, сумдын отрын штаб нь өөр аймаг болон өөрийн аймгийн сумдын нутагт отроор өвөлжиж, хаваржиж байгаа малчдад нийгмийн болон хүн, мал эмнэлэг, худалдаа, холбоо, төрийн үйлчилгээ үзүүлэх болон малчид хооронд үүсэх харилцааг зохицуулах үүрэгтэйгээр түр хугацаагаар байгуулагдан /2023 оны 11 дүгээр сарын 20-аас дараа оны 4 дүгээр сарын 20 хүртэл 150 хоног/ ажиллана.

1.2 Оторчдод үйлчлэх аймаг, сумын отрын штабын байршлыг тогтоох, бүрэлдэхүүнийг томилох, ажиллах журмыг батлах асуудлыг аймгийн Засаг даргын шийдвэрээр зохицуулна.

1.3 Аймаг, сумдын отрын штаб нь аймгийн Засаг даргын орлогч, Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Онцгой байдлын газар, Боловсрол соёл, урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газар, Мал эмнэлгийн газар, Хэвлэл мэдээллийн ажилтнууд, холбогдох сумдын удирдлагууд оролцсон бүрэлдэхүүнтэй байна.

1.4 Сумдад байрлаж ажиллах салбар штабууд нь түр байрлах ажлын өрөө, холбооны хэрэгсэл, унаа машин, орон байр зэрэг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангагдсан байх бөгөөд ажлын байрыг штаб байрлаж байгаа сум хариуцна.

1.5 Отрын штабуудын орон байр, хоол, унаа, томилолт, холбоо зэрэг үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлыг аймаг, сумдын Засаг даргын нөөц сан болон энэ талаар Засгийн газраас нэмэлтээр хуваарилсан хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

1.6 Өөр аймгаас отроор мал өвөлжүүлж, хаваржуулахгүй байх асуудлыг аймаг сумын отрын штаб хариуцан ажиллана.

1.7 Сумдын отрын салбар штабаас өвөлжөө, хаваржаа уст цэгийг актаар хүлээлгэн өгөх бөгөөд буцаж гарах үедээ оторчид өвөлжөө, хаваржаа уст цэгийн орчмыг цэвэрлэж, сэг зэмийг устгаж, албан ёсоор штабын ажлын хэсэгт хүлээлгэн өгөх болон оторчдоос гаргасан элдэв зөрчил, дутагдал, хохирлыг төлж барагдуулах ажлыг отор оруулсан сумдын Засаг дарга нар хариуцна.

1.8 Аймгийн отрын штаб нь отроор өвөлжиж, хаваржих малын тоог /квот/ сум бүрээр гарган, өвөлжүүлж хаваржуулах сумыг тогтоож өгнө. /

Хоёр: Отрын штабын дарга, гишүүдийн хүлээх үүрэг

2.1 Отрын штабын гишүүд нь штабын харьяанд байгаа малчдаараа графикийн дагуу эргэж, оторчдын санал хүсэлтийг сонсож, элдэв маргаан зөрчлийг зохих хууль, журмын дагуу шийдвэрлэнэ. Шаардлагатай арга хэмжээг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлж өгнө.

2.2 Отроор яваа малчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааг хийж, тэднийг малын хулгайн болон бусад гэмт хэрэгт орохоос урьдчилан сэргийлж ажиллана.

2.3 Сумдын салбар штаб нь отроор яваа малчдын мал өвөлжилт, хаваржилт малын онд оролт, төл бойжилт, хүн, малын өвчлөл, хорогдол зэрэг шаардлагатай мэдээллүүдээр аймгийн төв штабыг хангаж ажиллана.

Гурав: Аймгийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1 Аймаг, сумдын отрын штабыг тодорхой удирдлагаар хангаж, тэднийг ажил үүргээ гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаж ажиллана.

3.2 Отрын штаб, отроор яваа малчдаас ирүүлсэн улс, аймагтай холбоотой асуудлуудыг шийдвэрлэж өгөхөд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллана.